



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 651

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 171,033,600.00 (нэг зуун далан нэгэн сая гучин гурван мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, 169,990,888.00 (нэг зуун жаран есөн сая есөн зуун ерэн мянга найман зуун наян найман) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Тээврийн цагдаагийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав, Тээврийн цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа Д.Амарсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА



0002724

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
657 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан эзлэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Гарааш (2 машины)	2010.12.31	1,881,600.00	1	1,881,600.00	838,888.00	1,042,720.00
2	Контторын барилга	1968.01.01	167,328,000.00	1	167,328,000.00	167,328,000.00	-
3	Хашаа (төмөр)	1999.01.01	1,824,000.00	1	1,824,000.00	1,824,000.00	-
Дүн					171,033,600.00 (нэг зуун далан нэгэн сая гучин гурван мянга зургаан зуун төгрөг)	169,990,888.00 (нэг зуун жаран есөн сая есөн зуун ерөн мянга найман зуун наян найман төгрөг)	1,042,720.00 (нэг сая дөчин хоёр мянга долоон зуун хорин төгрөг)